

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурал 2022 оны 54 дүгээр тогтоолоороо “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 01, 02 дугаар тогтоол гарсантай холбогдуулан хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн харилцан хяналт-тэнцлийг хангах хүрээнд төрийн эрх барих дээд байгууллагад ард түмнийг төлөөлөх Улсын Их Хурлын гишүүдийн тоог шинэчлэн тодорхойлох, Улсын Их Хурлын сонгуулийн дэвшилтэт тогтолцооны зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулах асуудлыг судлан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”-ийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах зорилгоор олон нийтийн саналыг судлах сэдвийн хүрээ”-г тодорхойлж, үүнд сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх, сонгогчдыг төлөөлөх мандатын тоог нэмэгдүүлэх асуудлыг тусгасан.

2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр улс төрийн 21 нам Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг гаргаж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн хамрах хүрээнд “сонгуулийн холимог систем бүхий... олон намын оролцоотой зөвшилцлийн ардчилалд шилжих,” “сонгогчдыг төлөөлөх мандатын тоог нэмж, Улсын Их Хурлын нэг гишүүний нөлөөллийн эрх мэдлийг багасгах” -ыг дэмжиж, тунхаг бичиг гаргасан.

Монгол Улсын Их Хурлаас улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатайгаар тодорхойлох, асуудлын эрэмбэ, шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх, үндэсний зөвшилцлийг хангах зорилгоор зохион байгуулсан “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын дүнгийн талаарх зөвлөмжид иргэдийг төлөөлөх парламентын чадавхыг нэмэгдүүлж, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх талаар, Улсын Их Хурлын сонгуулийг явуулахдаа олонхын болон хувь тэнцүүлсэн тогтолцоог хослуулах нь зүйтэй талаар тус тус дэмжсэн дүн гарсан.

Эдгээр хууль зүйн үндэслэл, практик шаардлагад тулгуурлан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад ард иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, улс төрийн намуудын оролцоог хангах хүрээнд төслийг танилцуулах, хэлэлцүүлэх, саналыг авах ажлыг зохион байгуулав. Тухайлбал,

2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулагдсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаар улс төрийн 25 намын удирдлага, иргэний нийгэм болон судлаачдын төлөөлөл оролцоотой хэлэлцүүлэгт Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг дэлгэрэнгүй танилцуулж, хэлэлцүүлэв.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулахад иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах үүрэг бүхий ажлын дэд хэсгийг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг оролцоотойгоор байгуулж, тэдгээрт төслийн талаар танилцуулж, хэлэлцүүлэв.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл, үндэслэл тайлбарыг Засгийн газрын [/https://mongolia.gov.mn/](https://mongolia.gov.mn/) болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын [/https://cabinet.gov.mn/](https://cabinet.gov.mn/) цахим хуудас, түүнчлэн хуулийн төслийн хэлэлцүүлгийн d-parliament [/https://d.parliament.mn/](https://d.parliament.mn/) цахим хуудаст тус тус байршуулж төслийн талаар иргэд, олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулсан.

Түүнчлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн гишүүд, эрдэмтэд, судлаачдын төлөөллөөс бүрдсэн багууд төслийг иргэдэд танилцуулан хэлэлцүүлж, санал авах 22 хэлэлцүүлгийг 21 аймагт зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт нийт 6000 орчим иргэн биечлэн оролцож, 5000 гаруй саналын хуудсаар давхардсан тоогоор 33900 гаруй санал өгсөн байна.

Улс төрийн бүх намд төслийг хүргүүлж, саналыг авах ажлыг зохион байгуулав. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Шүүхийн ерөнхий зөвлөл, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын Ерөнхий прокурор, болон Засгийн газрын гишүүдийн саналыг авсан болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлд дараах асуудлыг тусгав.

1991-1992 онд Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж батлах үед Улсын Их Хурлын гишүүдийн тоог тухайн үеийн нийт хүн амын тоонд үндэслэн нэг гишүүн дунджаар 27 мянган иргэнийг төлөөлөхөөр тооцоолж, 76 гишүүнтэй байхаар хуульчилсан. Харин өнөөдөр нэг гишүүн дундажаар 44.7 мянган иргэнийг төлөөлөх болсон бөгөөд ингэснээр нэг гишүүний төлөөлөх иргэдийн тоо бараг хоёр дахин нэмэгдэж, парламентын төлөөлөх чадамжийг бууруулж байна. Цөөн гишүүнтэй парламентуудын хувьд хууль тогтоомж цөөн гишүүний саналаар батлагдах, нэг гишүүнд эрх мэдэл төвлөрөх, зүй бус нөлөөлөл орох, хуулийн биелэлтэд тавих хяналт сулрах зэрэг эрсдэл үүсдэг. Парламентын засаглалтай олон улсад парламент нь дунджаар 150-аас доошгүй гишүүнтэй байдаг нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хуваарилалт, хяналт-тэнцлийг хангахад үр нөлөөтэй байна. Тиймээс иргэдийг төлөөлөх парламентын чадамжийг сайжруулах зорилгоор Улсын Их Хурлын гишүүдийн тоог 152 болгон хүн амын тоотой уялдуулан нэмэгдүүлэхээр төсөлд тусгалаа.

Мажоритар сонгуулийн тогтолцоог дангаар хэрэглэх нь иргэдийн санал гээгдэх, тойргийн ашиг сонирхол улс орны эрх ашгаас өндөрт тавигдах, олон нийтэд танигдсан, хөрөнгө санхүүгийн боломжтой хүмүүст давуу байдал үүсгэх зэрэг сөрөг талыг бий болгож ирсэн. Пропорциональ аргыг сонгуулийн тогтолцоонд хэрэглэх нь сонгогчдын санал бага гээгдэх, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл жигд орох, бодлогын намыг төлөвшүүлэх зэрэг давуу талтай. Иймд мажоритар болон пропорциональ аргын давуу талуудыг тусгасан сонгуулийн тогтолцоотой болох, Улсын Их Хурлын нийт гишүүний тавин хувийг мажоритар, тавин хувийг пропорциональ аргаар сонгох зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт оруулахаар тусгалаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл батлагдсанаар ард түмнийг төлөөлөх парламентын чадавхыг сайжруулах, хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг чанаржуулах замаар Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгаа болсон парламентын засаглалыг төгөлдөржүүлнэ. Монгол Улсын Үндсэн хуульд сонгуулийн тогтолцоог тодорхой зааж баталгаажуулснаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо тогтвортой байх, намууд сонгуульд шударгаар өрсөлдөх, иргэдэд ойлгомжтой байх, гадаадад байгаа иргэний сонгох эрхийг баталгаажуулах ач холбогдолтой.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг төслийг дагалдуулан түүнийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг боловсруулна. Улсын Их Хурлаас гаргах хуваарийн дагуу Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт орно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ